# ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

## “Арван долдугаар зууны Монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд” таван боть ном

Монгол түүхэн сурвалжийн дотор онцгой байр суурьтай “Хураангуй алтан товч”, Лувсанданзаны “Алтан товч”, “Эрдэнийн товч”, “Шар тууж”, “Асрагч нэртийн түүх” хэмээх XVII зууны таван түүхэн сурвалжийн судалгааг уншигч таны оюуны мэлмийд өргөн толилуулж байна.

1. ***Хаадын үндсэн хураангуй алтан товч***, эх бичгийн цогц судалгаа үйлдсэн Ш.Чоймаа, УБ, 2011. Хэмжээ 260x350, ISBN 978-99962-1-295-6, DDC 907.2’517 Ч-756.
2. ***Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой (Лу. Алтан товч),*** эх бичгийн цогц судалгаа үйлдсэн Ш.Чоймаа, УБ, 2011, Хэмжээ 260x350, ISBN 978-99962-1-292-5, DDC 907.2’517 Ү-756.
3. ***Эртний монголын хаадын их шар тууж***, эх бичгийн судалгаа хийсэн С.Чулуун, Ш.Цэрэндоо, УБ, 2011. Хэмжээ 260x350, ISBN 978-99962-1-296-3, DDC 907.2’517 Ч-891.
4. ***Хаадын үндэсний эрдэнийн товч***, эх бичгийн судалгаа хийсэн М.Баярсайхан, УБ, 2011. Хэмжээ 260x350, ISBN 978-99962-1-293-2, DDC 907.2’517 Б-384.
5. ***Асрагч нэртийн түүх***, эх бичгийн судалгаа хийсэн Д.Заяабаатар, УБ, 2011. Хэмжээ 260x350, ISBN 978-99962-1-294-9, DDC 907.2’517 З-336.

зэрэг түүхэн сурвалж эхийн өнгөт хуулбар, эх бичгийн иж бүрэн судалгааны хамт оржээ. Эхний хоёр сурвалжийг МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг Алтай судлалын тэнхимийн багш доктор, профессор Ш.Чоймаа, гутгаар сурвалжийг ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгийн захирал, доктор С.Чулуун, дөтгөөр сурвалжийг МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг Алтай судлалын тэнхимийн эрхлэгч, доктор М.Баярсайхан, тавдугаар сурвалжийг Японы Осакагийн Их Сургуулийн зочин профессор, доктор Д.Заяабаатар тус тус судалж эрдэм шинжилгээний оршил, тайлбар бичин, галиг, хөрвүүлэг, үгийн хэлхээг хийсэн байна.

Уг таван ботид өнгөт хуулбар нь орсон таван эх бол тухай тухайн сурвалжийнхаа дэлхий дэх цорын ганц буюу хамгийн шилдэг тулгуур эхүүд бөгөөд цөм Монгол улсад (Үндэсний номын сан буюу хувь хүнд) хадгалагдаж буй хосгүй үнэт номд тооцогддог билээ.

Эрдмийн суварга болсон уг таван ботийн тулгуур эхийг Монгол Улсын гавьяат багш, төрийн соёрхолт, профессор Ш.Чоймаа санаачлан удирдаж, “Болор судар” хэвлэлийн газар хэвлэжээ.



# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ







## ФРАНЦИС ВҮҮДМЭН КЛИВИЗ
## (1911-1995)

### АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН НЭРТ МОНГОЛЧ ЭРДЭМТЭН ФРАНЦИС ВҮҮДМЭН КЛИВИЗИЙН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ

**ХӨТӨЛБӨР**

14:00 МУИС-ийн ректор, Монгол Судлалын Хүрээлэнгийн Ерөнхийлөгч, профессор Санжбэгзийн Төмөр-Очир хурал нээж үг хэлнэ.

14:10 Монгол Судлалын Хүрээлэнгийн захирал, д-р, дэд проф. Ж.Бат-Ирээдүй, "Нэрт монголч эрдэмтэн Ф.В.Кливизийн амьдрал бүтээлийн тухай товч"

**ХЭЛЭЛЦЭХ ИЛТГЭЛҮҮД:**

14:20 Академич Домийн Төмөртогоо, (ШУА, ХЗХ) **"КЛИВИЗ БА МОНГОЛ ХЭЛНИЙ БИЧГИЙН ДУРСГАЛУУДЫН СУДАЛГАА"**

14:40 Проф, Д-р Шаравын Чоймаа, Магсарын Баярсайхан (МУИС, ЭБАСТ) **"1362 ОНЫ ИНДҮ ВАНГИЙН ХӨШӨӨНИЙ БИЧЭЭС ХИЙГЭЭД КЛИВИЗИЙН СУДАЛГАА"**

15:00 Проф. Д-р, Цэвэлийн Шагдарсүрэн, (УБДС, МСТ) **"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ УГ ЭХИЙН ТУХАЙД"**

15:20 Д-р Мягмарсүрэнгийн Ууганбаяр, (МУИС, ХШТ) **"1272 ОНЫ НУР АД ДИНИЙ БИЧИГТ ГАРАХ ЗАРИМ ҮГИЙН ТУХАЙ"**

15:40 Д-р Очирбатын Самбуудорж, (ШУА, ХЗХ) **"МОНГОЛ ХЭЛНИЙ ЖУРАМЛАХ ХУВИЛБАР, БУРУУ ДУУДЛАГА ҮҮСЭХ АСУУДАЛД"**

16:00 Д-р, дэд проф. Лувсанжавын Чулуунбаатар, (МУИС, ГХТ) **"МОНГОЛ ҮГИЙН АМИН ХҮЧ БУЮУ ЭНЕРГИ"**

16:20 Д-р Лувсанцэрэнгийн Цэрэнчимэд, (Дорнод ДС) **"ЭХ БИЧВЭРИЙН НАЙРУУЛГАД САНАА АХИУЛАХ БА БУУРУУЛАХ НЬ"**

16:40 Д-р Мягмарын Саруул-Эрдэнэ, (АНУ, Төрийн Департментийн Гадаад Харилцааны Дээд сургууль) **"ЗЕНОГИЙН ПАРАДОКСЫГ МОНГОЛ ҮГИЙН БҮТЦЭЭР БАТЛАХ НЬ"**


Хурал зохион байгуулагч:
МУИС-ийн МОНГОЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН
МУИС-ийн ЭХ БИЧИГ, АЛТАЙ СУДЛАЛЫН ТЭНХИМ
И-мэйл: ims_num@mail.mn, Утас: 77307730-2509, 99115206


Эрдэм шинжилгээний хурал:
2011 оны 08 дугаар сарын 08 ны 14:00 цагаас
МУИС-ийн Төв байрын дугуй танхимд эхлэнэ